

**“ХУЛГАЙЛАГДСАН, ЭСХҮЛ ХУУЛЬ БУСААР
ЭКСПОРТЛОГДСОН СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН ТУХАЙ
ЮНИДРУА-ГИЙН КОНВЕНЦ”-ЫГ СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН
УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2022

Бүртгэлийн дугаар:

Нууцын зэрэглэл ...

Гэрээний дугаар *СОЯ-21/424*

**“ХУЛГАЙЛАГДСАН, ЭСХҮЛ ХУУЛЬ БУСААР
ЭКСПОРТЛОГДСОН СОЁЛЫН ЭД ЗҮЙЛСИЙН ТУХАЙ
ЮНИДРУА-ГИЙН КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН
ТАНДАН СУДАЛГАА”
(Захиалгат ажлын тайлан)**

Гүйцэтгэгч: МУИС-ын ХЗС-ийн докторант, судлаач Ч.Доржсүрэн

**Тайланг хянаж,
Баталгаажуулсан:**

Захилагч байгууллага: Соёлын Яам, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газар

Тайланг өмчлөгч: Монгол Улсын Соёлын Яам

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо,
Денверийн гудамж

Утас: 51265622/51265626

Цахим шуудан: info@moc.gov.mn

АГУУЛГА

| | |
|--|-------|
| Товчилсон үгийн жагсаалт | ii |
| Хүснэгт, зургийн жагсаалт | iii |
| УДИРТГАЛ | 1-2 |
| НЭГ. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ | 3 |
| 1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ | 3-5 |
| 1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд | 5-7 |
| 1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл | 7-10 |
| ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОЛ | 10-11 |
| ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАР, ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛ | 12-19 |
| ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨ | 19 |
| 4.1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө | 19-21 |
| 4.2. Эдийн засагт үзүүлэх нөлөө | 21-23 |
| 4.3. Нийгэмд үзүүлэх нөлөө | 24-26 |
| 4.4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө | 26-27 |
| 4.5. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн нийцэл | 27-68 |
| ТАВ. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХАРЬЦУУЛАЛТ | 69-72 |
| ЗУРГАА. НЭГДСЭН ДҮГНЭЛТ | 73-77 |
| ДОЛОО. ЗӨВЛӨМЖ | 78-79 |
| АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ | 80-84 |

ХАВСРАЛТ 1 (Монгол Улсын соёлын биет өвтэй холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомжууд)

ХАВСРАЛТ 2 (Монгол Улсад бүртгэгдсэн соёлын өвийн эсрэг гэмт хэргийн судалгаа)

ХАВСРАЛТ 3 (Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн конвенцид нэгдэн орсон, гарын үсэг зурсан улсуудын мэдээлэл)

ХАВСРАЛТ 4 (Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн конвенцын хавсралт болон Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бусад эрх зүйн актуудад тодорхойлсон соёлын эд зүйл /соёлын биет өв/-ийн ангилалын харьцуулалт)

ХАВСРАЛТ 5 (Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн конвенцыг соёрхон батлах, нэгдэн орох, гарын үсэг зурах үед улсуудын хийсэн мэдэгдэл)

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|------------------|---|
| ААҮАТЗТХ | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль |
| АНУ | Америкийн нэгдсэн улс |
| БНМАУ | Бүгд найрамдах монгол ард улс |
| БНХАУ | Бүгд найрамдах хятад ард улс |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| ГЕГ | Гаалийн ерөнхий газар |
| ГХЯ | Гадаад харилцааны яам |
| ИХШХШТХ | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль |
| НУБ | Нэгдсэн үндэсний байгууллага |
| ОХУ | Оросын холбооны улс |
| СӨХТХ | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |
| УИХ | Улсын их хурал |
| ХБНГУ | Холбооны бүгд найрамдах герман улс |
| ХЗЯ | Хууль зүйн яам |
| ЭХХШТХ | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль |
| ЭЦА | Эрүүгийн цагдаагийн алба |
| ЮНЕСКО /UNESCO | Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага |
| ЮНИДРУА/UNIDROIT | Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн |

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1-р хүснэгт. Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

2-р хүснэгт. Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалттай түүх, соёлын үл хөдлөх дурсгалын статистик

3-р хүснэгт. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын дүн

4-р хүснэгт. Асуудлыг зохицуулах хувилбар, зэрэг, сөрөг тал, зардал, үр өгөөжийн харьцаа

1-р зураг. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн Конвенц"-д нэгдэн орсон, гарын үсэг зурсан улсууд

2-р зураг. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн Конвенц"-д Монгол Улс нэгдэн орох боломжийг судлах дугуй ширээний уулзалт

УДИРТГАЛ

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллагын хүсэлтээр “Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” 1970 оны ЮНЕСКО-гийн Конвенцын шийдэж чадаагүй хувийн эрх зүйд хамаарах асуудлыг шийдвэрлэсэн, соёлын эд зүйлсийг хулгайлсан эсвэл хууль бусаар экспортолсон тохиолдолд эгүүлэх болон буцаан олгоход дөхөм болох зорилготой¹ “Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн”² буюу ЮНИДРУА-гаас боловсруулсан “Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай конвенц”-ын төслийг 1995 оны 6 дугаар сарын 7-ноос 24-ний өдрүүдэд Италийн Ром хотноо дипломат бага хуралд оролцогч улсууд хэлэлцэн баталсан юм.

ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс 2003 онд хамтран зохион байгуулсан “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүсийн сургалт семинар”-ийн төлөөлөгчдөөс ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенц болон ЮНЕСКО-гийн 2001 оны “Усан доорхи соёлын өвийг хамгаалах тухай” Конвенцид Монгол улсыг боломжийн богино хугацаанд нэгдэн орох асуудлыг тавьж шийдвэрлүүлэх³ талаар анх Монгол Улсын Засгийн газарт зөвлөмж болгосон. Мөн “Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх чадавх дээшлүүлэх” ЮНЕСКО-гийн төслийн хүрээнд Монакогийн Итгэлцлийн сангийн санхүүжилтаар зохион байгуулсан сургалт хэлэлцүүлгээс Монгол Улсын Засгийн газарт хандан гарсан 2011 оны Үндэсний Зөвлөмжид ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенц болон ЮНЕСКО-гийн 2001 оны Усан доорхи соёлын өвийг хамгаалах тухай Конвенцид Монгол улсыг хугацаа алдалгүй нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлэх⁴ тухай тусгажээ.

Түүнчлэн 2014 оны НҮБ-ын 69 дүгээр Ерөнхий Ассамблейн 69/196 дугаар тогтоолоор баталсан “Соёлын үнэт зүйлийн худалдаа болон бусад холбогдох гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн шүүхийн шийдэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон улсын удирдамж”⁵-д НҮБ-ын гишүүн орнууд “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай” 1954 оны Гаагийн Конвенц болон түүний хоёр Протокол, “Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” 1970 оны ЮНЕСКО-гийн Конвенц, “Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай” 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенц болон бусад холбогдох конвенцуудыг соёрхон баталж, хэрэгжүүлэх шаардлагатайг онцлоод, улс бүр эрүүгийн хэргийн олон улсын хамтын ажиллагааг сайжруулахын тулд хууль бусаар экспортолсон, импортолсон, хулгайлсан, дээрэмдсэн, хууль бусаар малтсан,

¹ Х.Эрдэмбилэг. “Соёлын эд зүйлсийн эгүүлэг ба буцаалт: ЮНИДРУА-гийн Конвенц. УБ., 2018 он. 37 дахь тал

² The International Institute for the Unification of Private Law (UNIDROIT) <https://www.unidroit.org/>

³ “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүсийн сургалт семинар” эмхтгэл, УБ хот. 2003 он. 7 дахь тал.

⁴ “ЮНЕСКО-Монакогийн хамтын ажиллагаа” Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх чадавх дээшлүүлэх төсөл. Үр дүнгийн Тайлан 2009-2011 (I үе шат). УБ хот 2013 он. 22 дахь тал.

⁵ General Assembly. Resolution adopted by the General Assembly on 18 December 2014. 69/196. International Guidelines for Crime Prevention and Criminal Justice Responses with Respect to Trafficking in Cultural Property and Other Related Offences. Distr.: General 26 January 2015

хууль бусаар худалдаалагдсан соёлын үнэт зүйлсийг буцаах, буцаан олгох, эх оронд нь буцаах чиглэлд зохих арга хэмжээ авах талаар анхаарах ёстойг дурдсан байна.

Дээрх зөвлөмжүүд болон олон улсын удирдамжийн дагуу Монгол Улсын Гадаад хэргийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2015 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/44, А/168 дугаар хамтарсан тушаалаар "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид нэгдэн орсноор үндэсний хууль тогтоомж, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийг судалж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий БСШУСЯ-ны дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдаж, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссын захиалгаар 2015-2016 онд уг конвенцид нэгдэн орохтой холбоотой эрх зүйн орчны судалгаа хийгдсэн билээ.

Монгол Улсын Их хурлаас 2010 онд Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах арга замыг батлан тодорхойлохдоо түүх, соёлын үнэт зүйлс хууль бусаар гадаадад гарахаас сэргийлэх, хилийн чанад дахь монгол соёл иргэншлийн өвийг сурвалжлан олох, судлах, эх орондоо эгүүлэн залах, сэргээн засах чиглэлээр иргэдийн санал, санаачилгыг дэмжиж, гадаад оронтой идэвхтэй хамтран ажиллах эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авна⁶ хэмээж, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.5.9-д хилийн чанад дахь монгол соёлын өвийг сурвалжлан олох, судлах, нэгдсэн каталог хийх, эх орондоо эргүүлэн залах, энэ чиглэлээр бусад улс оронтой идэвхтэй хамтран ажиллана,⁷ "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.6.3.7-д соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулна,⁸ "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 1.1.4-т соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлнэ, 1.5.2-т хилийн чанадад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулна⁹ гэсэн зорилтуудыг дэвшүүлжээ.

Ингээд Монгол Улсын Их хурал, Засгийн газрын бодлого, зорилтын хүрээнд "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид нэгдэн орохтой холбоотой эрх зүйн орчны судалгааны тайланд тулгуурлан энэхүү ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенцыг соёрхон батлах тухай хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилсан тандан судалгааг "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"¹⁰-ыг баримтлан гүйцэтгэлээ.

⁶ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.4.7 дахь заалт. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолын хавсралт

⁷ Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13 өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

⁸ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт

⁹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

¹⁰ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт. Жич: Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т заасны дагуу олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулахад энэ аргачлал хамаарахгүй гэж заасан боловч конвенцид нэгдэн орох хэрэгцээ шаардлагыг системтэй судалж зөв тодорхойлох, үр нөлөөг урьдчилан тооцох үүднээс дагаж мөрдөв.

НЭГ. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дэлхийн улс бүр өөрсдийн соёлын өвийг хамгаалах үндэсний эрх зүйн орчныг бүрдүүлсэн байдаг. Манай улс 1924 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Ардын Засгийн газрын хурлаар баталсан "Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм"-ээс эхлээд 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр УИХ-аас баталсан "Соёлын өвийг хамгаалах тухай хууль" /шинэчилсэн найруулга/, үе үеийн эрүүгийн болон иргэн, зөрчлийн тухай хууль, холбогдох бусад эрх зүйн актуудаар соёлын өвтэй холбоотой аливаа харилцааг зохицуулж, түүх, соёлын дурсгалт зүйлсээ хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай. Өнөөдрийн байдлаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем¹¹-д Монгол Улсын Үндсэн хууль 1, Монгол Улсын хууль 800, Монгол Улсын олон улсын гэрээ 660, Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг 211, УИХ-ын тогтоол 2099, Засгийн газрын тогтоол 4849, Сайдын тушаал 815, Засгийн газрын агентлагын даргын тушаал 329 бүртгэлтэй байгаагаас соёлын биет өвийг хайх, судлах, бүртгэх, тээвэрлэх, сурталчилах, шинжлэх, хувилах, ашиглах, худалдан авах, борлуулах, шилжүүлэх, бэлэглэх, хадгалах, тооллого хийх, авран хамгаалах, хилээр нэвтрүүлэх, эрэн сурвалжлах, эргүүлэн авчрах зэрэг үйл ажиллагааг зохицуулсан 3 олон улсын олон талт гэрээ, 46 хууль, 30 гаруй дүрэм, журам хүчин төгөлдөр үйлчилж байна. /Хавсралт 1/

Даярчлалын эринд эдийн засаг, нийгэм, соёлын харилцаа ганц хоёр улсаар хязгаарлагдахаа больж, соёлын үнэт зүйлсийн худалдаа нь хил дамнасан олон улсын томоохон бизнес болон өргөжсөн. Харамсалтай нь хууль ёсны худалдаанаас гадна хууль бус худалдаа дэлхий дахинд өсөн нэмэгдэж байна.¹² Соёлын үнэт зүйлсийн хууль бус наймааг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх үндсэн арга нь улс орнуудын засгийн газар, хууль, хяналтын байгууллага хоорондын гадаад хамтын ажиллагаа, эрх зүйн гол хэрэгсэл нь олон улсын гэрээ юм. Бид ч үүнийг аль хэдийн ухамсарлаж, "Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай" 1954 оны Гаагийн Конвенцид 1964 оны 11 сарын 04-нд, "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай" ЮНЕСКО-гийн 1972 оны Конвенцид 1990 оны 02 сарын 02-нд, "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" 1970 оны ЮНЕСКО-гийн Конвенцид 1991 оны 01 сарын 04-нд тус тус нэгдэн орсон билээ. Цаашид соёлын өвийн хамгаалалтыг сайжруулах, соёлын үнэт зүйлийн хууль бус худалдаатай тэмцэхэд дотоодын хууль тогтоомжийг чанд мөрдөх, нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийг хангахын зэрэгцээ цаг үеийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн холбогдох хуулиудыг улам боловсронгуй болгох, Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас илүү нарийн зохицуулалт бүхий олон улсын конвенцуудыг судалж, соёрхон батлах асуудал зүй ёсоор тавигдана.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ

БНМАУ-ын Бага хурлын хоёрдугаар чуулганаар "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай Конвенц"-д нэгдэн орох эсэх асуудлыг хэлэлцсэн бөгөөд ГХЯ-ны танилцуулгад ...энэхүү конвенцид нэгдэн орсноор өөрийн соёлын үнэт зүйлсийг хил дамнаулан алдахаас хамгаалах талаар бусад оролцогч улс болон ЮНЕСКО-той хамтран ажиллах боломжтой болох юм. Нөгөөтэйгүүр, конвенц манай улсын хувьд хүчин төгөлдөр

¹¹ www.legalinfo.mn 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдөр

¹² "Legal and Practical Measures Against Illicit Trafficking in Cultural Property" UNESCO handbook. International Standards Section Division of Cultural Heritage, 2006. p 3

болсноос хойш соёлын үнэт зүйлс гадагш алдагдсан байвал тэдгээрийг эгүүлэн олж авах талаар оролцогч бусад улстай хамтран ажиллах боломж нээгдэж байна¹³ гэж дүгнэсэн байдаг.

Гэвч 1970 оны ЮНЕСКО-гийн Конвенцын заалтууд хэт ерөнхий шинжтэй учир шууд хэрэгжүүлэхэд ихээхэн асуудалтай тулгардаг. Уг конвенцын хамтын ажиллагааны механизм, хамгаалалтыг бүрэн ашиглахад олон улсын жишигт нийцсэн тусгай зохицуулалт заавал байх шаардлагатай болно гэсэн үг. Энэ шаардлагыг хангаж чадах, ялангуяа хулгайлагдсан, хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлсийг эгүүлэн олгох, буцаах, зохих ёсоор хянамгай хандсныг тогтоох, шударга эзэмшигчид нөхөн төлбөр төлөх талаарх зохицуулалт бүхий олон улсын баримт бичиг бол 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенц юм. ЮНИДРУА-гийн Олон улсын хүрээлэнгийн ахлах мэргэжилтэн Марина Шнейдер 1995 оны Конвенцын талаарх танилцуулга илтгэлдээ:¹⁴ “Энэ салбарын бусад олон улсын баримт бичгүүдийг (1970 оны Конвенцийг хамруулан) бодвол 1995 оны Конвенцийг нэгдэн орсны дараа шууд хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Ямар ч тохиолдолд эрх зүйн үндэслэл болж чадахаар хангалттай нарийвчлан тодорхойлсон заалтуудтай” болох тухай өгүүлсэн юм.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд: Монгол Улсын ерөнхийлөгч хууль бусаар алдагдсан соёлын өвийг Монгол Улсыг төлөөлөн гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нэхэмжлэх эрхийг итгэмжлэлээр олгох, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох,¹⁵ Засгийн газар улсын хилээр гарч алдагдсан соёлын биет өвийг эргүүлэн авчрах ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагад чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих¹⁶ бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлж, хууль бусаар гадаадад гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, эсхүл палеонтологи, археологийн олдворыг судалж шинжлүүлэх болон гадаад улсад үзэсгэлэнд эргүүлэн авчрах нөхцөлтэйгээр улсын хилээр гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болохыг зарлах бөгөөд эргүүлж авчрах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цагдаагийн байгууллага хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулахаар зааснаас өөр зүйлгүй бөгөөд 1970 оны ЮНЕСКО-гийн Конвенцыг эс тооцвол хууль бусаар гадаад улсад гаргасан, эсхүл оруулж ирсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг эгүүлэн авах, буцаах ажиллагааг журамласан хууль, эрх зүйн акт Монгол улсад одоогоор алга байна. Гадаад улсад хууль бусаар оршин байгаа соёлын эд зүйлтэй холбоотой асуудлыг дан ганц дотоодын хууль тогтоомжоор шийдвэрлэх боломжгүй. Тиймээс ч 2022 оны 01 сарын 01-нээс даган мөрдөгдөж буй Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 27 дугаар зүйлд хууль бусаар алдагдсан соёлын өвийг эргүүлэн авчрах¹⁷ чиглэлд олон улсын хамтын ажиллагааг дэмжиж, хөгжүүлэхээр тусгасан.

Асуудлын мөн чанар нь Монгол Улсын соёлын биет өв хилийн чанадад хууль бусаар гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд эрж олох, эх орондоо эгүүлэн залах, эрх зүйн орчин, нөхцлийг бүрдүүлэхэд оршин буйг онцлоод уг конвенцыг соёрхон батлах

¹³ БНМАУ-ын Бага хурлын хоёрдугаар чуулганы бичиг баримт. XXXI боть. Монгол Улс. Үндэсний төв архив. №2, №96 ХН:119. 1991.01.04.

¹⁴ Mission to Ulaanbaatar, Mongolia 24 to 26 June 2015 REPORT, Marina Schneider, Senior Officer, “UNIDROIT”

¹⁵ Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2014 он, №23 /836/

¹⁶ Мөн тэнд. 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2014 он, №23 /836/

¹⁷ Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021 он, №32

хэрэгцээ шаардлагыг тандан судалж, эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд, асуудлын шалтгаан нөхцөл, зохицуулалтын хувилбар, эерэг, сөрөг тал, үр нөлөөг тодорхойлох зорилгоор асуудлын цар хүрээг дараах байдлаар тогтоолоо.

Үүнд:

- ЮНИДРУА, түүний гишүүн орнууд, 1995 оны Конвенц, тус конвенцид нэгдэн орсон улсуудын байдал, хандлагыг судалж тодорхойлох,
- ЮНЕСКО-гийн 1970 оны Конвенц болон ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенц, холбогдох зарим олон улсын баримт бичгүүдийг харьцуулах,
- Соёлын биет өв болон олон улсын харилцааг зохицуулж буй дотоодын холбогдох хууль тогтоомжууд ба ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенцын зүйл, заалтуудыг тайлбарлан дүгнэх,
- Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл болон үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийг шинжлэн судлах,
- Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлсийн хууль бус эргэлт, соёлын өвийн эсрэг гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдлыг тогтоох,
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хулгайлах, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн тоон мэдээнд дүгнэлт хийх,
- Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаа, эгүүлэг, буцаалттай холбоотой гадаад, дотоодын ном, гарын авлага, тайлантай танилцаж ашиглах,
- Хууль бусаар гадаад улсад гаргасан түүх, соёлын дурсгалт зүйлсийн эргүүлэн авчирсан баримт, арга ажиллагааг үнэлэх зэрэг болно.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

Соёлын үнэт зүйлийн хулгай, дээрэм, тонуул болон хууль бус экспорт, импортын практикийг бүгд мэднэ. Эдгээр нь дэлхий даяарх музей, нийтийн болон хувийн цуглуулга, хууль ёсны өмчлөгч, эзэмшигчид, шашны барилгууд, соёлын байгууллагууд, археологийн дурсгалт газруудад хортойгоор нөлөөлдөг.¹⁸ Конвенцоор хэлэлцэн тохиролцогч аливаа улсын төр, байгууллага, хуулийн этгээд, иргэдийн өмчийг хууль ёсны эзэмшигчид эргүүлэн өгөх, буцаахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхийг зорьсон бөгөөд олон улсын хувийн эрх зүйн шинжийг агуулна. Гэхдээ энэхүү харилцаанд өмчлөлтэй холбоотойгоор “тухайн” улс голлох байр суурьтай оролцох ба тухайн улсын төрийн болон орон нутгийн, шашны, боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг хөндөгдөнө.

Монгол улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна. Тус зүйлийн 2 дахь хэсэгт: Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн¹⁹ гэжээ. Түүх, соёлын дурсгалт зүйл, оюуны бүтээл өв сан бол Монголын ард түмний олон үеийн бүтээл байдаг тул үе үеийнхний иргэдийн бүтээсэн үнэт зүйлийг хамгаалах нь үндэсний эрх ашгийг хамгаалах төрийн нэг үндсэн чиг үүрэг²⁰ юм. Тийм ч учраас түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа

¹⁸ “Legal and Practical Measures Against Illicit Trafficking in Cultural Property” UNESCO handbook. International Standards Section Division of Cultural Heritage, 2006. p 3

¹⁹ Монгол улсын үндсэн хууль. УБ, 1992 он. Төрийн мэдээлэл №1 /7/

²⁰ Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан. Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000 он.50 дахь тал

нутаг дэвсгэр, газрын хэвлий нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч²¹ ба дарагдмал үнэт зүйлс дотор түүх, соёлын дурсгалт зүйл байвал тэдгээрийг төрийн өмчлөлд шилжүүлнэ.²² Дотоодын хуулийн эдгээр зохицуулалт ЮНЕСКО/ЮНИДРУА-гийн Илрээгүй соёлын эд зүйлсийн төрийн өмчлөлийн загвар заалтуудын "өмнө нь өмчлөөгүй тохиолдолд илрээгүй соёлын эд зүйлс төрийн өмч мөн"²³ гэдэгтэй нийцнэ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хууль бусаар гадаадад гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, эсхүл зохих зөвшөөрөлтэйгөөр улсын хилээр гаргасан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болохыг зарладаг. Өөрөөр хэлбэл алдагдсан соёлын эд зүйл нь нийтийн, эсхүл хувийн өмчлөлд байх нь гол бус Монгол Улсынх гэдэг нь чухал. Ингээд конвенцын зохицуулалтын дагуу тухайн асуудалд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг дараах байдлаар тодорхойлов. /Хүснэгт 1/

| д/д | Нийгмийн бүлэг | Эрх, ашиг сонирхолд нөлөөлөх хэлбэр |
|-----|---------------------------------------|--|
| 1 | Хэлэлцэн тохиролцогч улс /Монгол улс/ | Хууль бусаар экспортлосон соёлын үнэт зүйлийг буцаах хүсэлтийг тухайн хэлэлцэн тохиролцогч улс гаргахаар Конвенцид заасан. Харин хулгайлагдсан соёлын эд зүйлийг эгүүлэн авах тухай нэхэмжлэлийг ямар субъект гаргахыг нарийвчлан тусгаагүй ч Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсэн гэж үзвэл төр /улс/ нэхэмжлэл гаргаж, итгэмжлэлээр гүйцэтгүүлж болно. |
| 2 | Хэлэлцэгч Улсын эрх бүхий байгууллага | Нэхэмжлэлийн зүйл буюу хулгайлагдсан соёлын эд зүйл нь төрийн болон орон нутгийн, хувийн музей, галерей, эрдэм шинжилгээний байгууллага, үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн номын сан, төв архив, аймаг, нийслэлийн архив, шашны байгууллагын өмчлөл, эзэмшилд байсан бол Конвенцын үйлчлэлд шууд хамаарна. |
| 3 | Соёлын биет өвийн хууль ёсны өмчлөгч | Соёлын биет өвөө алдсан хууль ёсны өмчлөгч хувь хүн, соёлын эд зүйлийн бүтээгч, эртний эдлэлийн худалдаа эрхлэгчид, сонирхон цуглуулагчид байна. Мөн нутгийн уугуул иргэд, овог, аймаг /үндэстэн, ястан, угсаатан/ энэ бүлэгт багтана. |
| 4 | Соёлын эд зүйлийн шударга эзэмшигч | Соёлын эд зүйлийг худалдан авсан эзэмшигч тухайн зүйлийг хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон болохыг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан нь тогтоогдвол /нотолбол/ түүнийг шударга эзэмшигч гэж үзэх бөгөөд зохих нөхөн олговор авна. |
| 5 | Бусад этгээд | Энд соёлын эд зүйлийг хулгайлсан, хууль бусаар экспортлосон, хууль бус болохыг мэдсээр байж худалдан авсан, бусдад |

²¹ Соёлын өвийг хамгаалах тухай хууль./шинэчилсэн найруулга/-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2014, №23 /836/

²² Монгол Улсын Иргэний хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэг. УБ, 2002 он. Төрийн мэдээлэл эмхэтгэл №7 /244/

²³ Provision 3 – State Ownership. Undiscovered cultural objects are owned by the State, provided there is no prior existing ownership. <https://www.unidroit.org/instruments/cultural-property/2012-model-provisions/>

шилжүүлсэн этгээд болон шударга эзэмшигчид нөхөн олговрыг сайн дураараа төлөх гуравдагч этгээдийг хамруулна.

Жич: Хэлэлцэн тохиролцогч аливаа улс, тэдгээрийн эрх бүхий байгууллага, иргэн, хуулийн этгээд нь нөгөө улсаас гаргасан эгүүлэх авах нэхэмжлэл, буцаах хүсэлтийг хангахад хариуцагчаар оролцоно.

1-р хүснэвт. Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд: Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн²⁴ гэснийг үл ойшоож болохгүй. Оршин тогтохуйн үндэс болсон монгол соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах асуудал газар зүйн өвөрмөц байршил, цөөн хүн амтай, мал аж ахуй, нүүдэлчин соёл бүхий олон жилийн агуу түүхт ард түмний хувьд нэн тэргүүнд тавигдах ёстой. Зөвлөлтийн нэрт судлаач П.К.Козлов 1926 онд Монголын тухай бичихдээ, “Газрын гадаргуу дээр болон дор өчнөөн их хөшөө дурсгал, олон янзын соёл иргэншлийг хадгалсан өөр ийм орон бараг байхгүй” гэсэн байдаг.²⁵

Соёлын биет өв нь танигдсан ба танигдаж амжаагүй хоёр шинж чанартай. Ил байгаа барилга байгууламж, урлагийн монументал бүтээл, ариун тагшин газар нутаг, музейн үзмэрүүд танигдсан өвд тооцогдох бол хараахан малтаж судлаагүй далд байгаа аливаа булш, хиргисүүр зэрэг нь танигдаагүй өвд хамрагдах²⁶ бөгөөд түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх эдгээр дурсгал нь түүх, соёл, шинжлэх ухааны чухал ач холбогдолтойгоос гадна соёл иргэншлийн аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хамгаалалтын зүйл болно. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт зааснаар соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилдаг.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогыг 2015 онд /БСШУС-ын 2015 оны А/108 дугаар тушаалаар/ анх удаа улсын хэмжээнд явуулж, 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэр дэх 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг тоолон бүртгэжээ. Харасалтай нь 2020 оны байдлаар Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэл зэрэг 10 газраас нийт 111 дурсгал дурсгал гэмтсэн, тоногдсон, зөөгдсөн тухай мэдээлэл ирүүлсэн байна. 2021 оны 5 дугаар сарын байдлаар соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 9754 дурсгалт газрын 90043 ширхэг түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлтэй байна.²⁷ Үүнээс “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”²⁸-д 196 дурсгал, “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”²⁹-д

²⁴ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 1.1.6 дахь хэсэг

²⁵ Д.Майдар. Монголын түүх, соёлын дурсгалт зүйлс 8. Москва, Прогресс хэвлэлийн газар. 1981 он. 148 дахь тал

²⁶ Соёлын өв судлал, бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлал, соёл урлагийн боловсрол* Соёлын чуулган угтсан хэлэлцүүлэг. УБ, 2012 он. 31 дэх тал

²⁷ Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын мэдээлэл. 2021 он

²⁸ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт

²⁹ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалын хавсралт

607 дурсгал, "Сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"³⁰-д 1496 дурсгалт газар, 11123 дурсгалыг оруулжээ. /Хүснэгт 2/

| Хамгаалалтын ангилал | Улс | Аймаг, нийслэл | Сум, дүүрэг |
|----------------------|-----|----------------|-------------|
| Архангай | 2 | 39 | 2279 |
| Баян-Өлгий | 1 | 33 | 4141 |
| Баянхонгор | 1 | 54 | - |
| Булган | 1 | 41 | 1130 |
| Говь-Алтай | 9 | 33 | - |
| Говь-Сүмбэр | - | 3 | 273 |
| Дархан-Уул | 1 | 2 | - |
| Дорноговь | 6 | 27 | - |
| Дорнод | 3 | 31 | - |
| Дундговь | 6 | 37 | - |
| Завхан | 6 | 23 | - |
| Орхон | 1 | - | 111 |
| Өвөрхангай | 1 | 72 | - |
| Өмнөговь | 1 | 35 | - |
| Сүхбаатар | 7 | 24 | - |
| Сэлэнгэ | 3 | 23 | - |
| Төв | 1 | 24 | 1127 |
| Увс | 6 | 10 | 2062 |
| Ховд | 9 | 18 | - |
| Хөвсгөл | 8 | 31 | - |
| Хэнтий | 1 | 33 | - |
| Улаанбаатар | 1 | 14 | - |

2-р хүснэгт. Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалттай түүх, соёлын үл хөдлөх дурсгалын статистик

"Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"³¹-ын дагуу БСШУС-ын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай А/648 дугаар тушаалаар түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын 1-ээс 2019 оны 3 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Улсын тооллогод төрийн өмчийн 19, орон нутгийн өмчийн 285, шашны өмчийн 3, нийт 307 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдаж, нийт 105.659.865.196 төгрөгийн үнэ бүхий 126810 дэсийн 276077 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдсон байна. /Хүснэгт 3/

| № | Улсын тооллогод хамрагдсан байгууллага (ЭЗТ) | Тоологдох хөдлөх дурсгалт зүйл | | Дугаан | | Хулгайд алдсан | | Салигдсан | | Гадаргад үзэсгэлэнд | | Тоологдсон хөдлөх дурсгалт зүйл | |
|-----------------|---|--------------------------------|---------------|------------|------------|----------------|-----------|-----------|-----------|---------------------|-----------|---------------------------------|---------------|
| | | дэс | тоолш | дэс | тоолш | дэс | тоолш | дэс | тоолш | дэс | тоолш | дэс | тоолш |
| 1 | Улсын музей-10, элн жүрээлэн-2, номын сан-1, эрх сургууль-3, сүм хийд-2 | 59331 | 132270 | 9 | 9 | | | 1 | 1 | 19 | 67 | 59302 | 132193 |
| 2 | Аймаг, орон нутаг, нийслэлийн музей-24, байгууллагын музей-3 | 48205 | 109622 | 68 | 86 | 2 | 2 | 21 | 23 | | | 48114 | 109511 |
| 3 | Сум, дүүргийн ОНСТ-261, сүм хийд-1 | 19728 | 35127 | 285 | 672 | 41 | 72 | 8 | 10 | | | 19394 | 34373 |
| нийт дүн | | 127264 | 277019 | 362 | 767 | 43 | 74 | 30 | 34 | 19 | 67 | 126810 | 276077 |

³⁰ 2020 оны 12 дугаар сарын байдлаар Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Сүмбэр, Орхон, Төв, Увс зэрэг 7 аймгийн ИТХ-аас харьяалах нутаг дэвсгэрийнхээ "Сум, дүүргийн хамгаалалтад байх үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ыг баталсан ба Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Улаанбаатар зэрэг 12 аймаг, нийслэлийн ИТХ-аас "Сум, дүүргийн хамгаалалтад байх үл хөдлөх дурсгалын жагсаалт"-аа баталгаажуулаагүй байна.

³¹ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

3-р хүснэгт. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллолын дүн

2020 онд улс, аймгийн 25 музей, 6 аймгийн 26 сумын орон нутаг судлах танхимийн нийт 51 байгууллага 966 дэсийн 1422 ширхэг үзмэрээр сан хөмрөгөө баяжуулж, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн байна. Улсын 4 музей, аймаг, орон нутгийн 6 музей, байгууллагын харьяа 1 музей, 1 сүм хийд, 15 аймгийн 87 сумын Орон нутаг сурталчлах танхим зэрэг нийт 99 байгууллагын 146,529,941 төгрөгийн үнэ бүхий нийтдээ 435 дэсийн 875 ширхэг хөдлөх дурсгалт зүйл "дутсан", "хулгайд алдсан", "солигдсон" шалтгаанаар тоологдоогүй байна.³²

2000 оноос хойш (2015 он хүртэл) музей, сүм хийд зэрэг газруудаас соёлын эд зүйлс хулгайлсан 41 гэмт хэрэг, иргэдийн орон байр, гэр сууцанд нэвтэрч үе дамжсан бурхан, шашны эд хэрэглэл, эртний хийцтэй хөөрөг, мөнгөн аяга, эмээл гэх мэт зүйлийг хулгайлсан гэмт хэрэг 375, булаах гэмт хэрэг 5, дээрэмдэх гэмт хэрэг 18, залилан мэхэлж авах гэмт хэрэг 8, завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 12 тус тус бүртгэгдсэн³³ бол Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга³⁴ хүчин төгөлдөр болсноос 2021 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд:

- Бурхан, шашны эд өлгийн зүйл хулгайлах гэмт хэрэг 43 (Орон нутаг дахь хийдүүдээс 14, иргэдийн орон байрнаас 29),
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг 13,
- Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэрэг 6,
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэрэг 5,
- Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх гэмт хэрэг 5,
- Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх гэмт хэрэг 4³⁵ тус тус бүртгэгдэн шалгагджээ. /Хавсралт 2/

Энэ төрлийн гэмт хэрэг нь хулгайлах, дээрэмдэх, залилан мэхлэх, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх болон мөнгө угаах зэрэг хэлбэрээр үйлдэгддэг ба мөн эртний булш бунхан, хиргисүүр ухаж сүйтгэх, тухайн булшнаас гарсан эд зүйлүүдийг хууль бусаар хил давуулан БНХАУ-руу худалдан борлуулах аргаар үйлдэгдэн гарч байна.³⁶ Гаалийн байгууллага 2017 онд улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэж байсан судар 91, бурхан /метал/ 3, зурмал бурхан 21, бичмэл бар 1, гуулин эдлэл 12, модон эдлэл 8, морины дөрөө 13, тамхины уут 1, хутганы хуй 1, шашны эртний эдлэл 5, 2019 онд судар 96, хонх 1, шашны эд зүйл 24, гуулин эдлэл 1, эртний эд зүйлс /метал/ 5, бурхан /метал/ 3, зурмал бурхан 20 ширхэг зэргийг хураан авчээ.³⁷

Сүүлийн 5 жилийн хугацаанд хулгайлах гэмт хэргийн улмаас алга болсон нийт 52 /2017 онд 16, 2018 онд 16, 2019 онд 12, 2020 онд 4, 2021 онд 4/ түүх, соёлын дурсгалт зүйлсийг улсын хэмжээнд эрэн сурвалжилж 22 эд зүйлийг олсон бол цаашид эрэн

³² Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл, судалгааны газрын мэдээлэл. 2021 он

³³ Ч.Доржсүрэн. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг. УБ, 2014 он. 63 дахь тал

³⁴ УИХ-ын чуулганаар 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

³⁵ Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл, дүн шинжилгээний албаны мэдээлэл. 2022 оны 2 сар.

³⁶ ЭЦА-ны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн танилцуулга. 2021 он

³⁷ ГЕГ-ын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын мэдээлэл. 2022 он

сурвалжлах шаардлагагүй нөхцөл байдал бий болсон /Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиар хэрэгсэхгүй болсон/ үндэслэлээр эрэн сурвалжлах ажиллагааг зогсоосон 17, олддоогүй 13 эд зүйл /тоногтой эмээл, хүрэл тогоо, зурмал, шавар болон цутгамал бурхан, суварга, хуучны ном, судар, сувдан даруулга³⁸ байгаа нь анхаарал татна. Одоогийн байдлаар Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага /ИНТЕРПОЛ/-ын хулгайлагдсан урлагийн бүтээлийн мэдээллийн санд 52,000 гаруй соёлын зүйл тайлбар, зурагтайгаа бүртгэгдсэн байна. Энэ нь дэлхийн хэмжээний хулгайд алдагдсан болон алга болсон урлагийн объектуудын талаарх цагдаагийн баталгаажсан цорын ганц мэдээллийн сан бөгөөд 1995 оны Хулгайлагдсан эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийн тухай ЮНИДРАУ-гийн конвенцын зохих шалгалтын тухай ойлголтыг тодорхойлсон олон улсын бүртгэлийн нэг юм.³⁹

Бид танигдаж амжаагүй соёлын биет өвийг судлан тогтоох, танигдсан соёлын биет өвийг бүртгэн хянах, түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйлсээ найдвартай хадгалан хамгаалах зүй ёсны шаардлагыг биелүүлснээр соёл иргэншлийн аюулгүй байдлаа хангаж, оршин тогтнохуйн дархлаагаа бэхжүүлэх учиртай. Дэлхийн ямар ч улс, үндэстэнд энэ зарчим үйлчилнэ. Алдсан соёлын эд зүйлсийг эрэн сурвалжлах, эргүүлэн авах явдал соёлын биет өвийг хамгаалж буйн нэг хэлбэр бөгөөд ийнхүү олж авах, бүртгэгдсэн, бүртгэгдээгүй түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоногдох болон түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс хулгайлагдах, хууль бусаар хил нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх нь асуудлын шалтгаан нөхцөл болно.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫН ТОМЬЁОЛОЛ

Хил дамнуулан зувчуулсан Тарбозавр батаарын араг яс болон бусад олдворыг 1970 оны Конвенцын оролцогч АНУ-ын Засгийн газар иргэн Эрик Прокопигоос хураан авч манай улсад эргүүлэн өгсөн нь Монгол Улс соёлын өвөө хамгаалж чадахыг дэлхий нийтэд харуулсан билээ.⁴⁰ Энэ нь 1970 оны Конвенцийг хэрэглэх хамгийн дээд боломж бололцоог ашиглаж тухайн олдворыг буцаан авсан тодорхой жишээ болсон юм. Учир нь 1970 оны Конвенцид хууль бусаар малтсан соёлын эд зүйлсийн асуудлыг нарийвчлан хөндөөгүй бөгөөд зөвхөн оролцогч улсын музей болон түүнтэй төстэй байгууллагуудын бүртгэгдсэн соёлын эд зүйлийг буцаах асуудлыг л тусгасан. Өөрөөр хэлбэл, хууль бусаар малтаж, /тухайн улс чухал ач холбогдолтой гэж бүртгэж аваагүй/ хил давуулсан соёлын үнэт зүйлсийг конвенцын хүрээнд шийдэх боломжгүй гэж шүүх татгалзах магадлал өндөр байв.

Зарим нэг оролцогч улс конвенцын 3 болон 9 дүгээр зүйлүүдэд⁴¹ өгсөн тайлбарт малтсан огноо, уугуул улсыг нь баталсан тохиолдолд хууль бусаар экспортолсон соёлын

³⁸ Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP сангийн мэдээлэл. 2021 он

³⁹ <https://www.interpol.int/Crimes/Cultural-heritage-crime/Stolen-Works-of-Art-Database>

⁴⁰ Х.Эрдэмбилэг. "Соёлын эд зүйлсийн эгүүлэг ба буцаалт: ЮНИДРАУ-гийн Конвенц. УБ, 2018 он. 29 дэх тал

⁴¹ "Соёлын үнэт зүйлсийн хууль бус экспорт, импорт, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" 1970 оны ЮНЕСКО-гийн Конвенцын 3 дугаар зүйл: Энэхүү конвенцын дагуу оролцогч улсуудаас батласан журмыг зөрчин соёлын үнэт зүйлсийг импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийг хууль бус гэж үзнэ. 9 дүгээр зүйл: Археологийн болон угсаатны зүйн материалыг хулгайлснаас үүдэж соёлын сан хөмрөг нь аюулд учирсан энэхүү конвенцид оролцогч аливаа улс холбогдох бусад оролцогч улсад хандаж болно. Энэ тохиолдолд конвенцид оролцогч улсууд шаардлагатай арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх, түүний дотор соёлын үнэт зүйлсээр худалдаа хийх, тэдгээрийг импортлох, экспортлоход хяналт тавих зэрэг олон улсын харилцан зохицуулсан үйл ажиллагаанд оролцох

үнэт зүйлийг буцааж авах боломжтойг үгүйсгээгүй ч эдгээр заалт нь хэт ерөнхий агуулгатай. Гагцхүү тус палеонтологийн олдворыг зөвхөн Монголын нутаг дэвсгэрээс олддог бөгөөд тодорхой богино хугацааны дотор гаргасан гэдгийг нотлох харьцангуй хялбар байсан нь түүнийг буцааж авахад нөлөөлсөн гол хүчин зүйл болсон. Хэрэв тухайн соёлын эд зүйл нь палеонтологийн олдворт хамаарахгүй, шашны эсхүл шашны бус чанартай археологийн, түүхийн өмнөх үе, түүх, утга зохиол, урлагийн ач холбогдолтой, бүртгэгдээгүй, хувийн өмчийн эд зүйл бөгөөд Монгол улсынх гэх шинжлэх ухааны нотолгоо хангалттай бус бол 1970 оны Конвенцын дагуу буцаахад хүндрэл үүсэх нь зайлшгүй.

Ерөнхийдөө Т-батаарын хэргийг Нью-Йоркийн шүүх хэрхэн шийдсэнийг ЮНИДРУА-гийн Конвенцын хэм хэмжээ, зарчмаар тайлбарлаж болно. Энэ нь иргэний шүүхэд нэхэмжлэл гаргасан, хулгайлсан этгээдийг эзэмших эрхгүй болохыг нотолсон, гэмгүй худалдан авагчийг зохих магдлан хяналтаар тогтоосон, хууль бусаар малтаж, хил нэвтрүүлсэн /өмнө нь бүртгэгдээгүй/ соёлын эд зүйлийг хууль ёсны өмчлөгчид нь буцаасан үйлдлээр илэрнэ. ЮНИДРУА-гийн Конвенцоор хүсэлт гаргагч улсын нутаг дэвсгэрээс тухайн соёлын эд зүйлийг хууль бусаар шилжүүлснээр тодорхой ашиг сонирхолыг ноцтой зөрчиж байгаа нь тогтоогдвол хүсэлтийг хүлээн авагч улсын шүүх болон бусад эрх бүхий байгууллага хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаах шийдвэр гаргана. Хулгайлсан өвийг эгүүлэн олгох зарчим нь маш хатуу бөгөөд хэрэв гэрээний тодорхойлолтод хамаарагдах өвийг хулгайлсан нь нотлогдвол ямар ч маргаангүй эгүүлэн өгөх ёстой. Өмнөх конвенцын 7(b)(i) заалтын хязгаарлагдмал хэрэглээг тэлж: хууль бусаар малтсан эсвэл хуулийн дагуу малтаад хууль бусаар хадгалсан соёлын эд зүйлийг хулгайлсан гэж үзээд бүртгэн тоолох боломжгүй олдворыг олон улсын гэрээгээр хамгаалсан⁴² юм.

Түүнчлэн Конвенцын 4 болон 6 дугаар зүйлд: ...хулгайлагдсан (хууль бусаар экспортлогдсон) соёлын эд зүйлийг эзэмшиж буй этгээд түүнийг худалдан авахдаа тухайн эд зүйлийг хулгайлагдсан болохыг мэдээгүй, мэдэх боломжгүй байснаа эсвэл тухайн эд зүйлийг худалдан авахдаа зохих идэвх зүтгэл гаргаснаа нотолж чадсан тохиолдолд шударга бөгөөд зохих нөхөн төлбөр авах эрхтэй болох, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: соёлын өвийг хамгаалах зорилго бүхий экспортыг зохицуулах хуулийн дагуу олгогдсон зөвшөөрлөөр хүсэлт гаргаж буй улсын нутаг дэвсгэрээс үзэсгэлэн, шинжилгээ судалгаа болон сэргээн засварлах зорилгоор түр хугацаанд экспортлогдсон соёлын эд зүйлс зөвшөөрлийн хугацаандаа эх орондоо эргэж ирээгүй бол хууль бусаар экспортолсон гэж үзнэ⁴³ гэх зэргээр тодорхойлсон нь оролцогч улсын соёлын өвийг хамгаалах, ялангуяа хууль бусаар экспортлогдсон соёлын үнэт зүйлсийг тогтоох, эргүүлэн авах, шударга эзэмшигчийн эрхийг хангахад чиглэжээ.

Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилго нь “Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай” 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид нэгдэн орох явдал юм.

үүрэгтэй. Тийнхүү харилцан тохиролцох хүртэл холбогдох улс бүр хүсэлт гаргагч улсын соёлын өвд нөхөшгүй хохирол учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг бололцооньхоо хэрээр авна.

⁴² Х.Эрдэмбилэг. “Соёлын эд зүйлсийн эгүүлэг ба буцаалт: ЮНИДРУА-гийн Конвенц. УБ., 2018 он. 30, 31 дэх тал

⁴³ Unidroit convention on stolen or illegally exported cultural objects. (Rome, 24 June 1995). Монгол Улсын Гадаад харилцааны яам. албан ёсны орчуулга, 2018.03.22

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАР, ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛ

Асуудлыг шийдвэрлэх зорилгыг биелүүлэхэд чиглэсэн зохицуулалтын хувилбаруудыг тогтоож, зардал, үр өгөөжийн харьцаа, эерэг болон сөрөг талыг дараах байдлаар гаргав.

| д/д | Хувилбар | Зорилгод хүрэх байдал | Эерэг, сөрөг тал | Зардал, үр өгөөжийн харьцаа |
|-----|---|--|------------------|--|
| 1 | "Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах | Зорилго, зорилт хэрэгжихгүй бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй. | Үр дүн сөрөг | Ямар нэг зардал гарахгүй. Үр ашиггүй. |
| 2 | Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх | Асуудлыг шийдвэрлэхэд зохих хэмжээгээр түлхэц үзүүлэх хэдий ч зорилгод хүрч чадахгүй. | Үр дүн сөрөг | Багагүй хэмжээний зардал гарна. Үр ашиг муутай. |
| 3 | Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх | Хулгай, хууль бус экспорттой холбоотой асуудлыг төр зах зээлийн механизмаар зохицуулах боломжгүй. | Үр дүн сөрөг | Тодорхой хэмжээний зардал шаардагдана. Үр ашиггүй. |
| 4 | Төрөөс санхүүгийн интервенц хийх | Төр зөвхөн санхүүгийн дэмжлэг, нөлөөлөл үзүүлснээр зорилго биелэхгүй. | Үр дүн сөрөг | Нэмэлт зардал гарна. Үр ашиггүй. |
| 5 | Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх | Тодорхой үйл ажиллагаанд тэдний оролцоо, хамтын ажиллагаа ач холбогдолтой боловч зохицуулалт дутагдах учир зорилго хангагдахгүй. | Үр дүн сөрөг | Их хэмжээний зардал гарна. Үр ашиг муутай. |
| 6 | Захиргааны шийдвэр гаргах | Гадаад орон, олон улс хоорондын харилцааг шууд зохицуулж чадахгүй бөгөөд дотоод шинж чанартай зарим асуудлыг шийдвэрлэнэ. | Үр дүн сөрөг | Тодорхой хэмжээний зардал гарна. Үр ашиг муутай. |
| 7 | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" конвенцыг соёрхон баталснаар зорилгодоо хүрнэ. | Үр дүн эерэг | Бага хэмжээний зардал гарна. Үр ашигтай. |

4-р хүснэгт. Асуудлыг зохицуулах хувилбар, эерэг, сөрөг тал, зардал, үр өгөөжийн харьцаа

Зохицуулалтын хувилбар: Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн

хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах хувилбараар асуудлыг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”,⁴⁴ 20 дугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их хурал хадгална.”⁴⁵ хэмээгээд Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт: Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа олон улсын гэрээг заавал соёрхон батална, 16 дугаар зүйлийн 16.3-т: Улсын Их Хурал ...өргөн мэдүүлсэн олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжсэн бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хууль... гаргана⁴⁶ гэжээ. Аргачлалын 5 дугаар зүйлийн 5.4-т тухайн асуудлыг гагцхүү хуулиар зохицуулах шаардлагатай болохыг Үндсэн хуульд онцлон заасан бол хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгохоор тусгасан юм.

Тиймээс “Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай” 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид нэгдэн орох зорилгын дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонговол зохицуулалтын хувилбар “ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенцыг соёрхон батлах хуулийн төсөл боловсруулж батлах” гэж тодорхойлогдоно.

Зорилгод хүрэх байдал: Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр зорилгодоо хүрч чадах эсэхийг тогтооход (1) тус конвенцид нэгдэн орсон улсуудын туршлага, (2) эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд болон салбарын мэргэжилтнүүдийн санал, (3) өмнө хийсэн судалгааны материал зэргийг харгалзах, ашиглах шаардлагатай.

(1) Засгийн газар хоорондын байгууллага болох Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн⁴⁷ буюу ЮНИДРУА 1926 онд байгуулагдсан. Энэ байгууллагын гол зорилго нь улс орнуудын хувийн эрх зүйг уялдуулж зохицуулах, жишиг дүрэм бэлтгэхэд оршдог бөгөөд өнөөдрийн байдлаар тус байгууллагын гишүүн 63 улс⁴⁸ байна. Монгол Улс ЮНИДРУА-гийн гишүүн биш ч түүний 2 баримт бичиг /Хөдөлгөөнт төхөөрөмжийн олон улсын ашиг

⁴⁴ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл, 1992 он, №1 /7/

⁴⁵ Мөн тэнд

⁴⁶ Олон улсын гэрээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №2

⁴⁷ The International Institute for the Unification of Private Law (UNIDROIT) is an independent intergovernmental Organisation with its seat in the Villa Aldobrandini in Rome. Its purpose is to study needs and methods for modernising, harmonising and co-ordinating private and in particular commercial law as between States and groups of States and to formulate uniform law instruments, principles and rules to achieve those objectives. <https://www.unidroit.org/about-unidroit/>

⁴⁸ Africa: Egypt, Nigeria, South Africa, Tunisia; The Americas: Argentina, Bolivia, Brazil, Canada, Chile, Colombia, Cuba, Mexico, Nicaragua, Paraguay, The United States of America, Uruguay, Venezuela; The Asia-Pacific Region: Australia, China, India, Indonesia, Iran, Iraq, Japan, Pakistan, Republic of Korea, Saudi Arabia; Europe: Austria, Belgium, Bulgaria, Croatia, Cyprus, The Czech Republic, Denmark, Estonia, Finland, France, Germany, Greece, The Holy See, Hungary, Ireland, Israel, Italy, Latvia, Lithuania, Luxembourg, Malta, Netherlands, Norway, Poland– Portugal, Romania, Russian Federation, San Marino, Serbia, Slovakia, Slovenia, Spain, Sweden, Switzerland, Turkey, The United Kingdom. <https://www.unidroit.org/about-unidroit/membership/>

сонирхлын тухай 2001 оны Кейптауны конвенц ба түүний нисэх онгоцны протокол/-т 2006 онд нэгдэн оржээ.⁴⁹

Харин “Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай” 1995 оны Конвенцид нэгдэн орсон 53 улс /Азербайжан, Алжир, Ангол, Аргентин, Афганистан, Бенин, Болив, Босни ба Херцеговина, Ботсвана, Бразил, Буркино фасо, Габон, Гана, Грек, Гватемал, Гондурас, Дани, Иран, Испани, Итали, Камбож, Колумб, Койтэ д’войр, Кипр, Лаос, Латви, Литва, Мадагаскар, Монтенегро, Мьянмар, Нигер, Норвеги, Өмнөд Африк, Румын, Того, Тунис, Унгар, Панама, Парагвай, Перу, Португал, Сири, Словяк, Словен, Финланд, Хойд Македон, Хорват, Хятад, Швед, Шинэ Зеланд, Эквадор, Эл Салвадор/ гарын үсэг зурсан 9 улс /Гүрж, Гвений, Замби, Нидерланд, Пакистан, Франц, Орос, Сенегал, Швейцарь/⁵⁰ байна. /Хавсралт 3/

Одоогоор конвенцид Латин америкийн ихэнх орнууд, Нордикын 4 улс, Африк тивийн 10 гаруй, зүүн болон өмнөд Европ, Ойрхи дорнод, зүүн Азийн хэд хэдэн улсууд нэгдэн оржээ. Эдгээр улсуудын дийлэнх хэсэг нь нийгэм, эдийн засгийн хувьд хөгжиж буй орны тоонд багтах бөгөөд соёлын өв нь эрсдэлд орж болзошгүй улсууд ажээ. Тухайлбал, Афганистан, Болив, Гондурас, Койтэ д’войр, Мадагаскар, Нигер, Румын, Перу, Сири зэрэг улсуудын нийт 16 байгалийн болон соёлын өв устгах аюулд буй өвийн жагсаалтад⁵¹ бүртгэгдсэн байна.

⁴⁹ 2001 Cape Town Convention on International Interests in Mobile Equipment and its Aircraft Protocol.

<https://www.unidroit.org/instruments/security-interests/aircraft-protocol/status/>

⁵⁰ <https://www.unidroit.org/instruments/cultural-property/1995-convention/status/>

⁵¹ Дэлхийн өвийн хорооноос “Аюулд орсон соёлын өвийн жагсаалт”-д нийт 52 өвийг бүртгээд байна.

<https://whc.unesco.org/en/danger/>

АНУ,⁵² Их Британи,⁵³ Австри⁵⁴, ХБНГУ⁵⁵, Япон⁵⁶ зэрэг хөгжингүй орнууд хараахан нэгдэн ороогүй ч сүүлийн 5 жилийн дотор Өмнөд Африк тэргүүтэй 16 “жигжиг” улс нэгдсэн байна. Манай хойд хөрш /ОХУ/-ийн хувьд 1996 оны 06 сарын 29-нд гарын үсэг зурсан /Тус

⁵² АНУ өөр шигээ том урлагийн зах зээлтэй Европын хэсэг орнууд Юнидройтын конвенцийг соёрхон батлах эсэхийг хүлээх болно. Ялангуяа 1970 оны ЮНЕСКО-гийн конвенцын түүхтэй холбоотойгоор энэ болгоомжлол нь улс төрийн гэхээсээ илүү прагматик шинж чанартай. ЮНЕСКО-гийн конвенцид АНУ болон бусад 70, 80 гаруй орон нэгдэн орсон ч урлагийн томоохон зах зээлтэй бусад улс орнууд уг конвенцид нэгдээгүй тул хууль бус урлагийн зах зээлийг “хуурай” болгож чадаагүй юм. АНУ-д гол эсэргүүцэл нь III бүлэгт чиглэгддэг. Энэ нь Америкийн эрх зүйн байдалд нөлөөлнө, учир нь АНУ-д соёлын объектуудыг экспортлохыг хориглодоггүй (хулгайлагдсан эд зүйлс, хууль бусаар ухсан эртний эд зүйлсийг эс тооцвол). Нэмж дурдахад урлагийн бүтээл цуглуулагчид, эртний эдлэлийн худалдаачид, цөөн хэдэн музейн дунд эсэргүүцэл идэвхтэй явагдаж байна.


⁵³ Их Британи конвенцын зорилгыг “сайшаалтай” гэж үзэж байгаа боловч соёрхон батлахаас татгалзаж байна. Гол бэрхшээл бол соёлын объектуудыг гэрээний дагуу тодорхойлох, хууль ёсны хөөн хэлэлцэх хугацаа юм. Эдгээр хугацаа нь соёлын дурсгалт зүйлийг үнэнч шударгаар олж авах үед шаардлагатай хичээнгүй байдлыг нотлох үүрэг хариуцлагатай хавсарч, хэт их эргэлзээ төрүүлж, соёлын объект эзэмшигчийн ашиг сонирхлын тэнцвэрийг алдагдуулж байна. Хэрэв ЮНИДРУА-гийн конвенцийг хэсэгчлэн соёрхон батлах боломжтой байсан бол Их Британи (Герман болон бусад аж үйлдвэрийн орнуудаас ялгаатай нь) II бүлгийг үгүйсгэх ч III бүлгийг хүлээн зөвшөөрөх байсан. (Учир нь энэ нь Их Британи үндэсний хууль болгон өөрчилсөн Европын холбооны удирдамжтай нийцэж байгаа) Шинэ Засгийн газар өөр бодолтой байгаа эсэхийг харах л үлдлээ.

⁵⁴ Австри улс ЮНИДРУА-гийн конвенцид гарын үсэг зураагүй бөгөөд соёрхон батлах бодолгүй байна. Гол эсэргүүцэж байгаа зүйл бол хууль бусаар гадагш гаргасан соёлын үнэт зүйлийн асуудлыг хөндсөн III бүлэгт заасан заалтуудыг эсэргүүцэж байна. Хууль бусаар экспортолж буй зүйлийн тайлбар нь улс орон бүрт дэндүү олон янз байдаг бөгөөд үүнийг тухайн улсын шүүгчид даатгадаг.

⁵⁵ Холбооны Бүгд Найрамдах Герман Улс ЮНИДРУА-гийн конвенцийг соёрхон батлахгүй. Холбооны засгийн газар нь соёлын асуудалд бүрэн эрхт эрх мэдэл бүхий Холбооны улсуудтай тохиролцон ажиллаж байна. Үндсэн аргууд нь дараахь зүйлийг багтаасан болно: хэрэв конвенц зөвхөн II бүлэг (Хулгайлагдсан соёлын эд зүйлсийг нөхөн төлүүлэх) гэж хязгаарласан бол гэрээнд нэгдэн ороход ямар ч асуудал гарахгүй. Гуравдугаар бүлгээс (Хууль бусаар гадагш гаргасан соёлын эд зүйлсийг буцаан олгох) дааж давшгүй асуудал үүсдэг. Өнгөрсөн зуунд Герман өөрөө үндэсний соёлын үнэт зүйлсээ ихээхэн алдагдуулсан гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай болсон. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл либерал байсан экспортын зохицуулалтыг өөрчлөх бодол алга. Үндэсний соёлын өвийн чухал объектуудын хаана байгаа талаар улс орнуудын ашиг сонирхлын талаархи ойлголт байдаг. Гэсэн хэдий ч конвенц зорилгоосоо хол давж байна. Олон хүчин чармайлт гаргасан ч III бүлгийн заалтууд хоёрдмол утгатай хэвээр байна. Мөн нөхөн олговрын заалт, шударгаар олж авсныг нотлох ачааллыг хуваарилах, хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа, зохион байгуулах газар, тухайн улсын эрх чөлөөний тухай заалтууд нь юу гэж тодорхойлогдож байгааг бие даан тодорхойлох асуудал нь эргэлзээтэй хэвээр байна. Конвенцийг соёрхон баталсны дараа цаг хугацаа ихсэх тусам үнэнч шударгаар олж авсны дараа зохих шалгалт хийсэн тухай нотлох баримт гаргах нь улам бүр хэцүү болж, урлаг, эртний эдлэлийн худалдаа ихээхэн доройтох болно гэж Герман эмээж байна.

⁵⁶ Япон улс ЮНИДРУА-гийн конвенцийг соёрхон батлахаар бэлтгээгүй байна. Соёлын үнэт зүйлийн тодорхойлолт нь сэтгэл түгшээж байна (Япон улс ямар соёлын объектыг хамгаалахаа урьдчилан тодорхойлох ёстой гэж үздэг), мөн сайн санааны үүднээс олж авсан зүйлээ хангалттай хамгаалж чадаагүй (тэдгээрийг хуулийн дагуу урт хугацааны хөөн хэлэлцэх аюул заналхийлж байна). Энэхүү конвенц нь соёлын эд зүйлсийг үйлдвэрлэдэг улс болон соёлын үнэт зүйлийг импортлогч улсуудын тоглоомын зүйл болно гэж таамаглаж байна. Энэхүү конвенц нь соёлын эд зүйлсийг үйлдвэрлэдэг улс орнуудыг дэмжсэн гэж харамсаж байна. Unidroit Convention on stolen or illegally exported cultural property report. Committee on Culture and Education Rapporteur: Mrs Margitta Terborg, Germany, Socialist Group. 5 February 1998. <http://assembly.coe.int/nw/xml/>

конвенцын дагуу түүнийг соёрхон баталж, хүлээн зөвшөөрч, эсхүл батлах⁵⁷ ёстой. Гэхдээ тусгайлан хугацаа заагаагүй./ бол өмнөд хөрш /БНХАУ/ 1997 оны 05 сарын 07-нд конвенцид нэгдэж, баталсан байна. /Зураг 1/



1-р зураг. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн Конвенц"-д нэгдэн орсон, варын үсэг зурсан улсууд

(2) "Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүсийн сургалт семинар"⁵⁸-ийн төлөөлөгчдөөс ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенцид Монгол улсыг боломжийн богино хугацаанд нэгдэн орох асуудлыг тавьж шийдвэрлүүлэх⁵⁹ талаар анх Монгол Улсын Засгийн газарт зөвлөмж болгосон, "Соёлын эд зүйлсийн хууль бус худалдаатай тэмцэх чадавх дээшлүүлэх" сургалт хэлэлцүүлгийн⁶⁰ оролцогчид /үндэсний мэргэжилтнүүд/-оос Монгол Улсын Засгийн газарт хандан гарсан 2011 оны Үндэсний Зөвлөмжид ЮНИДРУА-гийн 1995 оны Конвенцид Монгол улсыг хугацаа алдалгүй нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлэх санал гаргасан талаар удиртгал хэсэгт дурдсан билээ.

ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, ГХЯ, БСШУЯ, ХЗЯ хамтран Улаанбаатар хотод 2015 оны 06 сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсан "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид Монгол Улс нэгдэн орох боломжийг судлах дугуй ширээний уулзалтад ЮНИДРУА-гийн хуулийн ахлах мэргэжилтэн, итгэмжит төлөөлөгч, хатагтай Марина Шнайдер болон БСШУЯ, ХЗЯ, Гаалийн Ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар,

⁵⁷ Unidroit convention on stolen or illegally exported cultural objects. Article 11.2. (Rome, 24 June 1995). Монгол Улсын Гадаад харилцааны яам. Албан ёсны орчуулга, 2018.03.22

⁵⁸ ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газар, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс 2003 онд Улаанбаатар хотноо хамтран зохион байгуулсан.

⁵⁹ "Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай бүсийн сургалт семинар" эмхтгэл, УБ хот. 2003 он. 7 дахь тал.

⁶⁰ ЮНЕСКО-гийн төслийн хүрээнд Монакогийн Итгэлцлийн сангийн санхүүжилтаар ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссоос 2011 онд Улаанбаатар хотноо зохион байгуулсан

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Соёлын өвийн төв болон музейн төлөөлөлүүд оролцож, Монгол улс дахь соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, ЮНИДРУА-гийн Конвенцын талаар болон конвенцид нэгдэн орсон хууль эрх зүйн үр дагавар, ач холбогдол зэргийг хэлэлцсэн⁶¹ юм. /Зураг 2/ Хэлэлцүүлгийн үеэр ЮНИДРУА-гийн хуулийн ахлах мэргэжилтэн Марина Шнейдер 1995 оны Конвенцын тухай илтгэлдээ: Эх бичвэрийг боловсруулахад маш тодорхой, нэгдмэл хэм хэмжээ бий болгох зарчим баримталж улс орнуудын эрх бүхий байгууллагууд ижил, нэгдсэн байр сууринаас тайлбарлах нөхцлийг бүрдүүлээд тайлбар хийхийг зөвшөөрөөгүй (18) бөгөөд дотоодын хууль тогтоомжид оруулсан тусгай заалтуудаар хэрэглэх нөхцөл бүрддэг бусад гэрээ конвенцыг бодвол ямар ч тохиолдолд эрх зүйн үндэслэл болж чадах заалтуудтай болохоор шууд хэрэглэх боломжтой. Хэдийгээр Үндсэн хуульд "Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэж заасан ч 1970 оны Конвенцын заалтуудыг нарийвчлан боловсруулаагүй учир дотоодын хууль тогтоомж шиг дангаараа үйлчлэх боломжгүй⁶² талаар онцлон тэмдэглэсэн байдаг.



Зураг 2. "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид Монгол Улс нэгдэн орох боломжийг судлах дуагүй ширээний уулзалт

(3) ЮНИДРУА-гийн Конвенцид нэгдэн орохтой холбоотой эрх зүйн орчны судалгааны тайлангийн дүгнэлт хэсэгт: Манай улсад соёлын эд зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх харилцааг зохицуулсан төрөлжсөн /тусдаа/ хууль байхгүй бөгөөд эдгээр хууль, эрх зүйн актуудын хүрээнд зохицуулагдаж байна. Түүнчлэн улсын хилээр хууль бусаар оруулж ирсэн соёлын эд зүйлийг буцаах талаар холбогдох хууль тогтоомжид тусгайлан заасан зүйл алга. Эрүүгийн болон иргэний хэрэг, маргааныг шалгаж, шийдвэрлэх гадаад хамтын ажиллагаанд Иргэний болон Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх 2 талт гэрээ байгуулсан улсуудтай гэрээний дагуу харьцаж болох юм. Гэвч манай улсаас гадаадын 18 оронтой байгуулсан 2 талт гэрээнд соёлын эд зүйлийг эргүүлэн өгөх, буцаахтай холбоотой ямар ч заалт байхгүй. Нэгдэн орсон "Үндэстэн дамнасан зохион

⁶¹ <http://unesco.mn/mn/1311/>

⁶² Х.Эрдэмбилэг. "Соёлын эд зүйлсийн эгүүлэг ба буцаалт: ЮНИДРУА-гийн Конвенц УБ, 2018 он. 40 дэх тал

байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенц", "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай 1954 оны Конвенц" зэрэг бусад олон талт гэрээг хэрэглэж болох ч мөн л нарийвчилсан зохицуулалт дутагдана⁶³ гээд ЮНИДРУА-гийн Конвенц нь хулгайлагдсан соёлын эд зүйлийг эргүүлэн олгох, хууль бусаар хил гаргасан соёлын эд зүйлийг буцаах ажиллагааг олон улсын хувийн эрх зүйн талаас авч үзэн түүнийг хангах журмыг нэг мөр болгож, ЮНЕСКО-гийн 1970 оны Конвенцын зарчмыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болж чадсаныг тэмдэглэсэн байна. Эцэст нь Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож буй энэхүү конвенцыг Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжуудтай агуулга, зарчмын хувьд бүрэн нийцсэн, тухайн харилцаанд илүү нарийн зохицуулалтыг бий болгосон, энэ чиглэлийн бусад олон улсын баримт бичгүүдтэй уялдсан, соёлын өвийг хадгалж, хамгаалах үйл ажиллагааг дэмжсэн байх тул манай улс нэгдэн ороход бүрэн боломжтой⁶⁴ гэж дүгнэжээ.

Зардал, үр өгөөжийн харьцаа: Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлэхэд Олон улсын гэрээний тухай хуульд заасан олон улсын гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ хийх, томилолтоор ажиллах, төлөөлөгчид хүлээн авах, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, олон улсын гэрээ байгуулах, олон улсын гэрээнд нэгдэн орохтой холбоотой судалгаа хийх, хэрэгжлтийн тайлан хамгаалах, олон улсын гэрээг орчуулах, орчуулгыг хянан баталгаажуулах, олон улсын гэрээний тусгай хэвлэмэл хуудас, хавтас, үдээс, лац захиалах⁶⁵ зардал улсын төсвөөс гарах бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд захиргааны ачаалал, нэмэлт зардал үүсгэхгүй юм. Нийгэмд үзүүлэх үр өгөөж конвенцыг ашиглан эгүүлэн авчирсан, буцаан авсан соёлын эд зүйлийн үнэ цэнээр хэмжигдэх ба гарах зардлаас ямагт өндөр байна. Конвенцид нэгдсний дараа тодорхой соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаах үед гарах /хадгалалт, тээвэрлэлт, нөхөн олговор, баримт бичиг, бусад г.м/ зардал зохицуулалтыг хувилбарыг хэрэгжүүлэх зардалд хамаарахгүй.

Эерэг, сөрөг тал: Урьдчилан сэргийлэлт, нарийвчилсан зохицуулалт, өргөн хүрээний хамгаалалт бүхий алдагдсан соёлын өвийг эгүүлэн /буцаан/ авах үр ашигтай эрх зүйн орчныг бий болгож байгаагаар зохицуулалтын хувилбарын эерэг байдал илэрнэ. Мөн соёлын үнэт зүйлийн хууль бус худалдааг хумих, олон улсын соёлын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмэртэй. Харин "сөрөг" талыг дараах байдлаар тайлбарлаж болно. Өнөөдөр Монгол Улсад хууль бусаар оруулж ирсэн соёлын үнэт зүйлийн талаарх мэдээлэл, судалгаа байхгүй. Түүх, соёл, зах зээл, газар зүйн байршил, хуулийн хориглолт зэргээс шалтгаалан манайх импортлогч орон биш бөгөөд соёлын өвийн судлаач, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн албан хаагч болон эртний эдлэлийн худалдаа эрхлэгч, түүх, соёлын дурсгалт зүйл сонирхон цуглуулагч нар үүнийг хүлээн зөвшөөрдөг. Иймд конвенцид нэгдэн орвол бид "олж авсан" соёлын өвөө "алдана" гэдэг болгоомжлол илүүц юм. Шинэ гэрээний дагуу манайд нэхэмжлэл гаргах магадлалтай улсын тоо нэмэгдэхгүй. 1970 оны Конвенц 132 оролцогч улстайгаас гадна шинэ гэрээний бүх оролцогч улс өмнөх конвенцид элсэн орсон. Хэрэв үнэхээр алдагдсан өв нь манай улсад байвал ЮНИДРУА-гийн Конвенцын оролцогч улсууд 1970 оны Конвенцыг хэрэглэж⁶⁶ болох байсан. Учир нь тэд бүгд ЮНЕСКО-гийн конвенцид нэгдэн орсон. Магадгүй оролцогч аль нэг улс

⁶³ "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцид нэгдэн орохтой холбоотой эрх зүйн орчны судалгааны тайлан. УБ, 2016 он. 66-67 дахь тал

⁶⁴ Мөн тэнд. 85 дахь тал

⁶⁵ Олон улсын гэрээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №2

⁶⁶ Х.Эрдэмбилэг. "Соёлын эд зүйлсийн эгүүлэг ба буцаалт: ЮНИДРУА-гийн Конвенц. УБ, 2018 он. 35 дахь тал

/төр, байгууллага, иргэн/ нэхэмжлэл гаргасан тохиолдолд конвенцын дагуу тухайн хууль бус соёлын эд зүйлийг эгүүлэн өгснөөр "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ"⁶⁷ гэсэн үг. Гэхдээ конвенцыг зорилтот бүлэг, иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг орхигдуулж болохгүй.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨ

Сонгон авсан зохицуулалтын хувилбарын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг аргачлалд тусгасан шалгуур үзүүлэлт, суурь асуултуудын дагуу тандан судаллаа. Нийгэмд үзүүлэх үр нөлөө /4.3/ хэсгийн 8 /Соёл/-д судалж байгаа асуудлын онцлогоос хамаарч 2 асуулт нэмж оруулсан болно.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|--|--|---------|------|--|
| 1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх | | | |
| | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | Тийм | - | Улс, үндэстэн, овог, аймаг, уугуул иргэд, нийгмийн бусад бүлгийн соёлын өвийг хувийн, нийтийн гэж ялгаварлахгүй бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглал /2, 7, 8, 17, 22, 27, 28, 29/, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт /2, 15/, Монгол Улсын Үндсэн хууль /14, 16.3, 16.8, 16.14/-ийн холбогдох зүйл, заалттай бүрэн нийцнэ. |
| | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | - | Үгүй | |
| | 1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | - | |
| | 1.2.Оролцоог хангах | | | |
| | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | Тийм | - | Хувилбарыг сонгохдоо сургалт, уулзалт, хэлэлцүүлгээс гаргасан үндэсний болон ЮНИДРУА-гийн мэргэжилтэн /судлаач, археологич, хууль сахиулагч, музей, соёлын байгууллага, хил, гаалийн ажилтан г.м/ нарын санал, зөвлөмжийг харгалзсан ба эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдүүдийг |
| | 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй | Тийм | - | |

⁶⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Төрийн мэдээлэл, 1992 он, №1 /7/

| | | | | |
|--|--|------|------|--|
| | иргэдийг тодорхойлсон эсэх | | | судалгааны 1.2 хэсэгт 5 бүлэгт ангилж тодорхойлсон. |
| 1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага | | | | |
| | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | Тийм | - | Хүний өөрийнхөө туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны аливаа бүтээлтэй холбогдон үүссэн ёс суртахууны болон эд материалын ашиг сонирхлыг хамгаалуулах, эд хөрөнгө өмчлөх эрхийг хангах, хамгаалахад дэвшил гарна. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, НҮБ-ын зөвлөмжтэй нийцнэ. |
| | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | Тийм | - | |
| | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | Тийм | - | Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг эзэмшигч хууль ёсны өмчлөгчид буцаах ёстой. Шударга эзэмшигч нөхөн олговор авах эрхтэй. |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх | - | Үгүй | Соёлын эд зүйлийн эзэмшигч тухайн зүйлийг хулгайлагдсан, хууль бусаар экспортлогдсон эсэхийг мэдэх боломжтой байсан эсэхийг тогтоох нь түүний эрхийг хязгаарласан хэрэг биш. |
| | 2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | - | Үгүй | |
| 3.Эрх агуулагч | 3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх | Тийм | - | Хэлэлцэн тохиролцогч улс, төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага, хуулийн этгээд, соёлын эд зүйлийн хууль ёсны өмчлөгч, шударга эзэмшигч нь эрх агуулагч байна. |
| | 3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх | Тийм | - | Нутгийн уугуул иргэд, овог, аймаг эмзэг бүлэг болно. |

| | | | | |
|--|---|------|---|--|
| | 3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх | Тийм | - | Уугуул иргэд, овог, аймагт хамааралтай бөгөөд тэдний уламжлалт зан үйлд хэрэглэдэг, тухайн нийгмийн бүлэгт ач холбогдолтой соёлын эд зүйлийг эгүүлэн олгох нэхэмжлэлийн хугацаа харьцангуй урт /75 жил/ ба буцаах шийдвэр гаргах үндэслэл болно. Энэ нь бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон, эмзэг байдлыг харгалзсан зохицуулалт юм. |
| | 3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй) | Тийм | - | |
| 4.Үүрэг хүлээгч | 4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх | Тийм | - | Эрх агуулагчид Конвенцын дагуу зарим үүрэг хүлээнэ. |
| 5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | Тийм | - | Жендэрийн хувьд ялгавартай байх үзэл хандлага агуулагдаагүй. |
| | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | Тийм | - | Хүйсийн тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгаанд шууд сөргөөр нөлөөлөхгүй. |

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|--|---------|------|--|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, өрсөлдөөн, эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалтад ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
| | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | - | Үгүй | |
| | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | Тийм | - | Соёлын үнэт зүйлийн хууль бус худалдааны сөрөг нөлөөллийг бууруулна. |
| 2.Дотоодын зах зээлийн | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | - | Үгүй | Зах зээлийн өрсөлдөөн, үнийн |

| | | | | |
|--|--|------|------|---|
| өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх | - | Үгүй | хөөрөгдөл, монопол байдал бий болгохгүй. |
| | 2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | - | Үгүй | |
| | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | - | Үгүй | |
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | - | Үгүй | Аж ахуйн нэгжүүдэд ямар нэгэн зардал, үйл ажиллагааны хязгаарлалт, хориг саад учруулахгүй. |
| | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | - | Үгүй | |
| | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | - | Үгүй | |
| | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх | - | Үгүй | |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | Тийм | - | Төрийн захиргааны байгууллагаас мэдээлэхтэй холбоотой тодорхой /бага/ зардал гарч болно. |
| 5.Өмчлөх эрх | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх | Тийм | - | Хууль бус худалдаа /хулгай/, экспортоос үүдэн эзэмших, өмчлөх эрх, буцаалттай холбоотойгоор соёлын эд зүйлийн бүтээгчийн асуудал хөндөгдөнө. Хууль бус соёлын эд зүйлийг шилжүүлэн авснаар тодорхой хязгаарлалтад өртөнө. |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | Тийм | - | |
| | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | Тийм | - | |
| 6.Инноваци болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | - | Үгүй | Нээлт, шинэ бүтээл гаргах, үйлдвэрлэлийн |

| | | | | |
|------------------------------------|--|------|------|---|
| | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | - | Үгүй | технолги нэвтрүүлэх, дэлгэрүүлэх асуудалд нөлөөлөхгүй. |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | Хэрэглэгчийн эрх ашиг, санхүүгийн байдалд ямар нэг сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. |
| | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | - | Үгүй | |
| | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| | 7.4.Хувь хүний / гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх | - | Үгүй | Бүс нутаг, байгууллага, салбар, нэгжид ажлын байр нэмэх, хасах, нөлөөлөх зүйлгүй. |
| | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | - | Бага хэмжээний урсгал зардал гарна. |
| | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | - | Үгүй | Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгт ямар нэг өөрчлөлт оруулах шаардлагагүй. |
| | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх | - | Үгүй | |
| 10.Макро эдийн засгийн хүрээнд | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | Эдийн засаг, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалт, инфляцид нөлөөлөхгүй. |
| | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | - | Үгүй | |
| | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх | - | Үгүй | |
| 11.Олон улсын харилцаа | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | - | Венийн болон бусад олон улсын гэрээнүүдтэй нийцнэ. |

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|--|--|---------|------|---|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | - | Үгүй | Хувилбар нь ажлын байр бий болгох, эсхүл цомхотгохгүй бөгөөд тодорхой ажил, хөдөлмөр эрхлэгч болон ажил эрхлэлтэд сөрөг нөлөөгүй. |
| | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх | - | Үгүй | |
| | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх | - | Үгүй | Салбар, байгууллагын ажлын чанар, стандарт, ажилчдын эрх, үүрэг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй. |
| | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх | - | Үгүй | |
| | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | Тийм | - | Соёлын өвийн бүртгэл мэдээлэл, судалгааг улам сайжруулах шаардлага гарна. |
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх | - | Үгүй | Тэгш бус байдал үүсгэж, нийгмийн эмзэг бүлэгт сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
| | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт | - | Үгүй | |
| | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх | Тийм | - | Эзэмшилтэй холбоотойгоор шууд нөлөөлнө. |
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх | - | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй. |
| | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | Тийм | - | Холбогдох яам, агентлаг, байгууллага, |
| | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх | Тийм | - | албан тушаалтны үүрэг, үйл ажиллагаа, гадаад |

| | | | | |
|--|---|------|------|--|
| | | | | харилцаанд эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх | Тийм | - | Энэхүү эрхийг дэмжиж баталгаажуулна. |
| | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | - | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй. |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх | - | Үгүй | Нийтийн эрүүл мэнд, хүмүүсийн амьдралын хэв маягт ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
| | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх | - | Үгүй | Нийгмийн төрөл бүрийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмж, боловсролын тогтолцоо, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй. |
| | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх | Тийм | - | Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлнө. |
| | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх | Тийм | - | Хуулийн хэрэгжилтийг хангахад эерэгээр нөлөөлнө. |
| | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | - | Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн |

| | | | | |
|--------|--|------|------|--|
| | | | | илрүүлэлтэд нөлөөлнө. |
| | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | Ямар нэг сөрөг нөлөөгүй, харин хохирогчийн эрх ашгийг хамгаална. |
| 8.Соёл | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | - | Соёлын өвийг хамгаалахад чухал нөлөөтэй. |
| | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх | - | Үгүй | Хэл, соёлын ялгаатай байдалд сөрөг нөлөөгүй. |
| | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх | Тийм | - | Иргэдийн итгэл, үнэмшил, идэвх, оролцоог нэмнэ. |
| | 8.4.Хууль бусаар гадаад улсад гаргасан соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаах механизмыг бүрдүүлэх эсэх | Тийм | - | ЮНЕСКО-гийн 1970 оны конвенцын хэрэгжилтийг хангаж, гадаад улсад хууль бусаар гаргасан соёлын эд зүйлийг эгүүлэх, буцаах боломж бий болно. |
| | 8.5.Монгол Улс өмнө нь нэгдэн орсон соёлын хууль бус худалдаатай тэмцэх олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | - | |

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---------------------------------|---|---------|------|---|
| 1.Агаар | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | - | Үгүй | Агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүй. |
| 2.Зам тээвэр, түлш, эрчим хүч | 2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх | - | Үгүй | Зам тээвэр, түлш, эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
| | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | - | Үгүй | |
| 3.Ан амьтан, ургамлыг хамгаалах | 3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх | - | Үгүй | Ан, амьтан, ургамал, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
| | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх | - | Үгүй | |

| | | | | |
|---|---|---|------|--|
| | 3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| | 3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх | - | Үгүй | Хосолмол өв бүхий газар нутгийн хамгаалалтад эерэг нөлөөлнө. |
| 4. Усны нөөц | 4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх | - | Үгүй | Усны чанар, нөөцөд нөлөөлөхгүй. |
| | 4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | - | Үгүй | |
| | 4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх | - | Үгүй | |
| 5. Хөрсний бохирдол | 5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх | - | Үгүй | Хөрсний бохирдол, эвдрэл үүсгэхгүй. |
| | 5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх | - | Үгүй | |
| 6. Газрын ашиглалт | 6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх | - | Үгүй | Газрын ашиглалт, зориулалтыг өөрчлөхгүй. Харин газрын хэвлий дэх олдворыг хамгаална. |
| | 6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх | - | Үгүй | |
| | 6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх | - | Үгүй | |
| 7. Нөхөн сэргээгдэх /нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг | 7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | - | Үгүй | Байгалийн баялагийн ашиглалтад ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй. |
| | 7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх | - | Үгүй | |

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн нийцэл

Энэ дэд хэсэгт "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" 1995 оны ЮНИДРУА-гийн Конвенцын удиртгал, 5 бүлэг, 21 зүйл бүрийг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль, эрх зүйн актын зохицуулалттай харьцуулж, үзэл санаа, зарчим, утга агуулгад нийцэж буй эсэхийг зүйл бүрээр тайлбарлан дүгнэлээ.